

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ**Баримт бичгийн мэдээлэл**

Баримт бичгийн дугаар:

Баримт бичгийн хувилбарын дугаар:

Хүчин төгөлдөр болсон огноо:

Мэдээллийн ангилал:

Мэдээллийн түвшин:

Хариуцагч:

Хэрэглэгч:

ЖР-ТУЗ005 /ТУЗ-ийн хурлын 23/11/16-ны
өдрийн 23/016 тоот тогтоолын Хавсралт 4/

1.0

2023/11/16

Нийтэд хүртээмжтэй

3

ТУЗ-ийн дарга

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх
захирал

Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг
Баталсан: Г.Хатанболд	ТУЗ-ийн дарга	
Боловсруулсан: Ч.Жаргал	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	

Өөрчлөлтийн түүх

Хувилбарын №	Огноо	Боловсруулсан	Өөрчлөлтийн тайлбар	Хянасан	Баталсан
1.0	2023/11/16	Ч.Жаргал	Анхны хувилбар	ТҮЗ-ийн гишүүд	Г.Хатанболд

Түгээлт

Тайлбар
Айтүүлс ХК-ийн цахим хуудсаар хувьцаа эзэмшигч, олон нийтэд нээлттэй түгээгдэнэ.
Энэхүү баримт бичгийг хувилбарын дугаараар хянана.

ГАРЧИГ

1. Нийтлэг үндэслэл.....	4
2. Хугацаат тайлагналын мэдээлэл	4
3. Тухай бүр мэдээлэх мэдээлэл.....	5
4. Компанийн талаар мэдээлэл авах	6
5. Мэдээллийг хадгалах.....	7
6. Дотоод мэдээлэл.....	7
7. Нууц мэдээлэл	7
8. Бусад.....	7

1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн төрөл, хэлбэр, мэдээллийг компанийн хувьцаа эзэмшигч, хөрөнгийн бирж, зохицуулах байгууллага, олон нийтэд тайлагнах, хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 - 1.2.1. "мэдээллийг нээлттэй болгох", "олон нийтэд мэдээлнэ" гэж хууль тогтоомж, "Компанийн засаглалын кодекс" болон энэ журамд заасан мэдээллийг Монголын хөрөнгийн бирж /МХБ/ болон компанийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх, МХБ, Санхүүгийн зохицуулах хороонд /СЗХ/ цахим болон цаасан хэлбэрээр хүргэхийг;
 - 1.2.2. "хугацаат тайлагнал" гэж хувьцаа эзэмшигчдийн хурал болон хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх зорилгоор компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулсан тайланг;
 - 1.2.3. "тухай бүр мэдээлэл мэдээлэл" гэж хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нэлөө үзүүлэхүйц компанийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон нөхцөл байдалтай холбоотой мэдээллийг;
 - 1.2.4. "дотоод мэдээлэл эзэмшигч" гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1-д зааснаар дараах этгээдийг, үүнд:
 - 1.2.4.1. компанийн нэлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээд;
 - 1.2.4.2. албан үүргээ хэрэгжүүлэх, гэрээ, хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд болон тэдгээрийн холбогдох этгээд.

2. Хугацаат тайлагналын мэдээлэл

- 2.1. Хугацаат тайлагналд компанийн хагас жил, жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан хамаарна. Хугацаат тайлагналын хугацааг МХБ-ийн 2022 оны 5-р сарын 10-ны өдрийн 8 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам"-д зааснаар мөрдөх ба МХБ-ийн журамд өөрчлөлт орвол энэ журмын 2.2 болон 2.3-т заасан хугацааг МХБ-ийн журамд шинэчлэн зааснаар дагаж мөрдөнө.
- 2.2. Компанийн хагас жилийн санхүүгийн тайланг 7-р сарын 20-ны дотор, жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 2-р сарын 10-ны дотор МХБ, СЗХ-нд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ. Жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланг СЗХ-ноос зөвшөөрсөн аудитын байгууллагаар баталгаажуулан, дараа жилийн 4-р сарын 1-ний дотор МХБ-ийн цахим хуудаст байршуулан, олон нийтэд мэдээлнэ.
- 2.3. Хагас жилийн үйл ажиллагааны тайланг 7-р сарын 20-ны дотор, жилийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4-р сарын 1-ний дотор МХБ, СЗХ-нд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.
- 2.4. Жил, хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангийн мэдээллийг СЗХ-ны 2021 оны 6-р сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4-р хавсралтын дагуу бэлтгэхээс гадна дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- 2.4.1. компанийн бүтэц /толгой, охин, хараат, зэргэлдээ компаниуд, тэдгээрийн хувь эзэмшилийн хэмжээ/, холбоотой талуудын санхүүгийн гүйлгээний талаарх мэдээлэл;
- 2.4.2. дараах нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл:
 - 2.4.2.1. тухайн жилийн санхүүгийн тайллангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан;
 - 2.4.2.2. компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;
 - 2.4.2.3. компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;
- 2.4.3. тайлант хугацаанд эргүүлэн худалдан авсан халаасны хувьцааны тоо ширхэг, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн, үнэт цаасаар урамшуулсан талаарх мэдээлэл.
- 2.5. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд компанийн засаглалын талаарх мэдээллийг заавал тусгахаас гадна, СЗХ-ны 2022 оны 3-р сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хавсралт 1-ийн дагуу үнэлгээ тайлбарыг тайлганаж, МХБ, СЗХ-нд цахимаар хүргүүлэн, олон нийтэд мэдээлнэ.
- 2.6. Компани нь байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээр тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг /БОНЗ-ын тайлан/ МХБ-ийн “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ын хавсралт 1-ийн дагуу бэлдэж, компанийн жилийн үйл ажиллагааны тайлангийн хамт МХБ-д хүргүүлж болно.

3. Тухай бүр мэдээлэх мэдээлэл

- 3.1. Тухай бүр нийтэд нээлттэй болгох мэдээлэлд дор дурдсан нөхцөл байдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тооцох ба тухайн нөхцөл байдал үүссэнээс хойш Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56.1-д заасны дагуу ажлын нэг өдөрт багтаан мэдээллийг нээлттэй болгоно. Үүнд:
 - 3.1.1. компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц гэрээ, хэлцэл байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, дуусгавар болгох, татгалзах, тэрээний хугацаа дууссан;
 - 3.1.2. шүүх, прокурор, төрийн эрх бүхий байгууллагаас компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанийг хариуцагчаар татаж, захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн, шүүхээс дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу эрх хүлээн авагч томилогдсон;
 - 3.1.3. нийт активын 25 хувь ба түүнээс дээш хэмжээтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалсан эсхүл бусад компанийн хяналтын багц худалдан авсан талаарх мэдээлэл, холбогдох гэрээ, хэлцэл;
 - 3.1.4. борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл, лиценз, харилцагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлагдсан, дуусгавар болсон;
 - 3.1.5. компанийн эрх бүхий этгээдээс СТОУС-ын дагуу компанийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзэн дахин үнэлгээ хийлгэхээр шийдвэрлэсэн тохиолдолд холбогдох шийдвэр, уг шийдвэрийг гаргах болсон нөхцөл, шаардлага, үнэ

- цэнэ нь буурсан хөрөнгө болон хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хэмжээ эсхүл хязгаарын тооцоолол;
- 3.1.6. компанийн эрх бүхий этгээдээс компанийн өмнөх жилүүдийн санхүүгийн тайланц алдаа гарсан гэж үзсэн бол алдаатай санхүүгийн тайлангууд, алдаа гарсан гэж үзэх үндэслэл;
- 3.1.7. компанийн хяналтын багцыг бусад этгээдэд шилжүүлэх, нелөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд, хувьцаа эзэмшилд гарсан өөрчлөлт;
- 3.1.8. компанийн дотоод мэдээлэл эзэмшигч, түүнд гарсан өөрчлөлт, эрх бүхий албан тушаалтан, ТУЗ-ийн дарга, гишүүдийг томилж, чөлөөлөх;
- 3.1.9. компанийн дүрэмд өөрчлөлт оруулах;
- 3.1.10. Гүйцэтгэх захирал үүрэгт ажлаас чөлөөлөгдөх; нийт ажилтны 15 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох /чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орох/
- 3.1.11. компанийн ёс зүйн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;
- 3.1.12. үйл ажиллагаанд шинэ техник, технологи нэвтрүүлэх, зах зээлд нелөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулсан;
- 3.1.13. компанийн болон түүний охин, хараат компани үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл болон барааны тэмдэг эзэмших эрх хүчингүй болсон, цуцлагдсан эсхүл бусдад шилжүүлсэн, барьцаалсан;
- 3.1.14. оноосон нэр, үндсэн захиргаа, оршин байх хаяг байршил өөрчлөгдөх, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, эсхүл татан буулгах;
- 3.1.15. үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурь, түүнд гарсан өөрчлөлт, үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөх, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогсох;
- 3.1.16. компани төлбөрийн чадваргүй болох, татан буулгах чиглэлээр гаргасан шийдвэр;
- 3.1.17. хувьцаагаа эргүүлэн худалдан авах, халаасалсан хувьцааг бусдад шилжүүлэх, эргэлтэд гаргах тухай шийдвэр /тус шийдвэрт эргүүлэн худалдан авах, худалдах/шилжүүлэх/эргэлтэд гаргах зорилго, хувьцааны тоо ширхэг, үнэ, нийт хувьцаанд эзлэх хувь, төлбөр хийх хугацааг тусгана/;
- 3.1.18. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн;
- 3.1.19. дараа жилийн үйл ажиллагааны зорилт, төлөвлөгөө, төсөв;
- 3.1.20. хувьцааны үнэ ханшид нөлөөлж болох бусад мэдээлэл, шийдвэрүүд.
- 3.2. Тухай бүр мэдээлэх мэдээллийг СЗХ-ны 2021 оны 6-р сарын 11-ний өдрийн 225 тоот тогтооолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4-р хавсралтын 4, Маягт 3-ын дагуу тайлагнана.

4. Компанийн талаар мэдээлэл авах

- 4.1. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь холбогдох хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах боломжийг хувьцаа эзэмшигчид олгох үүрэгтэй.
- 4.2. Компанийн цахим хуудсанд үйл ажиллагааны мэдээлэл болон “Компанийн засаглалын кодекс”-т заасан бодлогын баримт бичгүүд, дотоод дүрэм, журам, зааврыг байршуулж, цаг тухайд нь шинэчлэн хөрөнгө оруулагч, бусад оролцогч талуудыг мэдээллээр хангана.

5. Мэдээллийг хадгалах

- 5.1. Нийтэд мэдээлсэн мэдээллийн баримт бичгийг 5 жилийн хугацаагаар хадгалах ба уг хугацаа дуусмагц архивт шилжүүлнэ.
- 5.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь нийтэд мэдээлсэн мэдээллийн баримт бичгийг хүлээн авах, хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивд шилжүүлэх ажлыг хариуцаж гүйцэтгэнэ.

6. Дотоод мэдээлэл

- 6.1. Дотоод мэдээлэл эзэмшигч нь компанийн дотоод мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан мэдээллийг нээлттэй болгохоос өмнө санамсаргүй болон санаатайгаар ашиглах, бусдад мэдээлэх, дамжуулах, олж авах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.
- 6.2. Компани нь хуурамч, бусдыг төөрөгдүүлсэн мэдээллийг нийтэд мэдээлэхгүй.

7. Нууц мэдээлэл

- 7.1. Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон компанийн "Мэдээллийн хөрөнгийн журам"-д заасан мэдээллийг нууц мэдээлэл тэх ба нууц мэдээллийг шүүх, цагдаа, татвар зэрэг төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд задруулахыг хориглоно.

8. Бусад

- 8.1. Энэхүү журам нь ТУЗ-ийн баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 8.2. Компанийн санхүү, үйл ажиллагааны тайланг гаргах, энэхүү журмын 3.1-д заасан мэдээллийг цаг тухайд нь ТУЗ-д мэдэгдэх, мэдээллийн үнэн зөвийг хариуцах үүргийг Гүйцэтгэх захирал хүлээнэ.
- 8.3. Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ, тайланг боловсруулах, компанийн аливаа тайлан, мэдээллийг хувьцаа эзэмшигч, олон нийтэд мэдээлэх, МХБ болон СЗХ-нд хүргүүлэх ажлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцна.
- 8.4. Энэ бодлогын хэрэгжилт, мэдээллийг үнэн зөвөөр, цаг тухайд нь нийтэд мэдээлж байгаа эсэхэд ТУЗ-ийн дарга хяналт тавина.
- 8.5. Шаардлагатай гэж үзвэл энэ бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах асуудлыг ТУЗ-өөс шийдвэрлэнэ.